

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025.12.25

Улаанбаатар хот

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр 2025 онд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1.Захиргааны удирдлагын чиглэлээр: Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүн, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон холбогдох бусад бодлогын баримт бичгүүдийг үндэслэн баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Монгол Улс Ази-Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний 10 дахь удаагийн Жилийн бүгд хурлын даргалагч улсаар сонгогдсоны хувьд тус бүгд хурлыг 2025 оны 9 дүгээр сарын 23-26-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Хуралд хөрөнгө буцаах сүлжээний гишүүн орнууд, хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын болон бүс нутгийн, үндэсний хэмжээний авлигатай тэмцэх байгууллага, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Ойрх Дорнод, Хойд Африкийн хөрөнгө буцаах байгууллагуудын сүлжээний буюу 3 олон улсын байгууллага, 13 гадаад улс орны 60, Монгол Улсын хууль сахиулах чиг үүрэг бүхий 13 байгууллагын 90, нийт 150 зочин, төлөөлөгч оролцлоо. Бүс нутгийн хэмжээнд авлигатай тэмцэж, шударга ёсыг бэхжүүлэх, хууль бус хөрөнгийн урсгалыг таслан зогсоох улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд энэхүү хурлын зорилго оршиж байгаа бөгөөд энэ удаагийн хурал “Цахим хөрөнгийг буцаан авах ажиллагаа болон хөрөнгийн менежментийн эрх зүйн зохицуулалт” үндсэн сэдвийн хүрээнд цахим хөрөнгийг буцаан авахад хиймэл оюун ухааны AI технологи хэрэглэх арга, сайн туршлага, яллахгүйгээр хөрөнгө хураан авах эрх зүйн зохицуулалт, бүс нутгийн хамтын ажиллагаа, хөрөнгийн менежментийн шинэ тренд зэрэг асуудлаар Австрали, Тайланд, Малайз, Филиппин, Папуа Шинэ Гвиней, Энэтхэг, Шинэ Зеланд улсын төлөөлөгчид илтгэл мэдээлэл хэлэлцүүлэн, олон улсын сайн туршлагаа хуваалцлаа.

Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваагийн урилгаар Малайз Улсын Авлигатай тэмцэх хорооны дарга Тан Шри Дато' Шри Азам бин Баки тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 2 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Монгол Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын хүрээнд хоёр тал авлигатай тэмцэхэд бүхий л чиглэлээр хамтран ажиллахад бэлэн байгаагаа санал нэгтэй илэрхийлж, “Монгол Улсын Авлигатай тэмцэх газар болон Малайз Улсын Авлигатай тэмцэх хороо хооронд авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурав.

Мөн Тайландын Хаант Улсын Авлигатай тэмцэх үндэсний хорооны дэд комиссар, ноён Паттарасак Ваннасаенг тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 6 дугаар сарын 9-13-ны өдрүүдэд Монгол Улсад ажлын айлчлал хийлээ. Талууд албан ёсны уулзалт хийж, байгууллага хоорондын найрсаг харилцаагаа цаашид улам гүнзгийрүүлэн хөгжүүлж, албан хаагчдыг мэргэшүүлэн сургах, харилцан туршлагаа солилцох, цаашид идэвхтэй хамтран ажиллахаар харилцан тохирч, Монгол Улсын Авлигатай тэмцэх газар болон Тайландын Хаант улсын Авлигатай тэмцэх үндэсний хороо хооронд авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хамтран ажиллах тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.

Энэхүү айлчлалууд нь Монгол Улс, Малайз Улс, Тайландын Хаант Улсын авлигатай тэмцэх байгууллагуудын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, хамтарсан сургалт дадлага зохион байгуулах, албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлэх, чадавхжуулах, харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагаанд чухал арга хэмжээ боллоо.

Бүгд Найрамдах Узбекистан Улсын Авлигатай тэмцэх агентлагтай авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нийтийн алба, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод,

нээлттэй байдлыг хангах талаар хамтын ажиллагааг өргөжүүлэх, сайн туршлага солилцох, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах, энэ чиглэлээр “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулах бэлтгэлийг ханган ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэж байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээний бүгд хуралд танилцуулагдсан Истанбулын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторингийн тайланг хүлээн авлаа.

Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-аас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал /2024–2027/” төслийн хоёрдугаар хөтөлбөрийн хүрээнд Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцоог бэхжүүлэх, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, түүний дотор хөрөнгө, орлого, зарлагыг хянах болон эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны чиглэлээр мөрдөгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг тус төсөлд үндэслэн хэрэгжүүлэхээр төлөвлөөлд байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 2024 оны 5 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 01 дүгээр тогтоол батлагдсаныг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

“Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2024”-ын талаарх мэдээлэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдсэн тайлан, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээллийг эмхэтгэн Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

Эрүүгийн хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт эрх бүхий албан тушаалтан ажиллаж байгаа бөгөөд эдгээр хууль болон Авлигын эсрэг хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Засгийн газрын Тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Худалдан авах ажиллагааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох хууль, журмын төсөлд тусгавал зохих саналуудыг хууль санаачлагчид болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам зэрэг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлав.

Тайлант хугацаанд байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулж байгаа 5 эрхийн актыг батлан мөрдүүлж, захиргааны хэм хэмжээний 1 актад нэмэлт, оруулж захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгүүлэв. Нийт 15 эрхийн актад нэмэлт, өөрчлөлт оруулж, холбогдох эрхийн актыг шинэчлэн найруулсныг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хяналт шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэгдлээ.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасныг баримтлан байгууллагын мэдүүлэг гаргавал зохих албан хаагчдын 2024 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон албан тушаалтнуудын 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэчилсэн бүртгэлийн тухай мэдээллийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-д зааснаар

холбогдох мэдээ, мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, ХАСХОМ-ийн тайлан, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийн статистик мэдээг боловсруулан Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Байгууллагын хэмжээнд 2025 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн 3034 гомдол, мэдээлэл хүлээн авснаас Мөрдөн шалгах хэлтэст 1766, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст 949, Гүйцэтгэх ажлын хэлтэст 164, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст 95, Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албанд 58 нь тус тус хуваарилагдан хянан шалгагдсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, өргөдөл, гомдол, мэдээлэл 243 нэгжээр өссөн, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 23 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

1.3. Гадаад харилцааны чиглэлээр: 2025 онд байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэх, Авлигын эсрэг конвенцийг хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын болон гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай нягт хамтран ажиллалаа.

1.3.1. Гадаад хамтын ажиллагааны талаар: Бүгд Найрамдах Узбекистан Улсын Авлигатай тэмцэх агентлагтай авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нийтийн алба, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар хамтын ажиллагааг өргөжүүлэх, сайн туршлага солилцох, албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, энэ чиглэлээр “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулах, хамтран ажиллах талаар тус агентлагийн эрх бүхий албан тушаалтнуудтай уулзалт хийж хэлэлцэн тодорхой асуудлуудаар шийдэлд хүрлээ.

2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг (АРТ)-ийн ахлах зөвлөх Бэн Баклэндийг Авлигатай тэмцэх газар (АТГ)-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа, АТГ-ын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал, Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням нар хүлээн авч уулзан, хоёр талын хамтын ажиллагаа болон мөрдөн шалгах ажиллагааны явцад үр дүнтэй мэдүүлэг авах загвар буюу PEACE model-ийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар харилцан ярилцав. Мөн 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа тэргүүтэй төлөөлөгчид ИБУИНХУ-ын парламент дахь Олон улсын парламентын холбоотой харилцах бүлгийн дарга Фабиан Хамильтон тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, авлигын эсрэг хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, олон улсын хамтын ажиллагаа, авлигын эсрэг эрх зүйн зохицуулалтын талаар танилцуулав.

2025 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Австралийн Холбооны Улсын Элчин сайдын яамны Дэд тэргүүн Андрю Бэрримэн болон улс төрийн ажилтан Хайдар Аршад, 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Австралийн Холбооны цагдаагийн олон улсын удирдлагын газрын Бээжин дэх төлөөлөгч, ноён Жефф Коклес болон тус улсын Элчин сайдын яамны улс төрийн ажилтан Хайдар Аршад, 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх газрын Бээжин дэх холбогч офицер Дэвид Сатклифф нарыг АТГ-ын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал хүлээн авч уулзан, АТГ-ын үйл ажиллагааг танилцуулж, хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

2025 оны 6 дугаар сарын 16-ны өдөр АТГ-ын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал ОУВС-гийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзан “Авлигатай тэмцэх жил”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, төсөв, санхүүгийн хяналт, төрийн өмчит компаниудын засаглалын талаар, 2025 оны 8 дугаар сарын 5-ны өдөр АНУ-ын Элчин сайдын яамны Бүс нутгийн аюулгүй байдлын хэлтсийн дарга Сара Бет Машл, хуулийн асуудал хариуцсан туслах атташе Шоун Сианг нарыг хүлээн авч уулзан цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар, 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Зүүн өмнөд Ази, Номхон далайн бүсийн дэд дарга Бенедикт Хоффман, тус албаны Монгол дахь бүсийн төлөөлөгч Дук Лонг Нгүеэн тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан албан хаагчдын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх сургалт болон цаашдын хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй ярилцаж, санал солилцов.

2025 оны 3 дугаар сарын 8-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын долоо дахь

ээлжит тайланг хэлэлцүүлэн хамгаалах арга хэмжээнд эрх бүхий албан хаагчид оролцож, холбогдох асуудлаар мэдээлэл өглөө. 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт хүний эрхийн алба (АИХЭА)-ны Хууль тогтоомжийн дэмжлэг үзүүлэх ажилтан Надия Сиренко, Сонгуулийн зөвлөх Горан Петров, шинжээч Фернандо Касал Бертоа нарыг АТҮХХХ-ийн албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, ХШДШХ-ийн албаны дарга, ахлах комиссар Б.Баярсайхан нар хүлээн авч уулзан, улс төрийн намын санхүүжилттэй холбоотой хууль эрх зүйн орчин, хяналтын механизмын талаар мэдээлэл өгч, олон улсын сайн туршлагын талаар санал солилцов.

Гадаад улс оронд зохион байгуулагдсан “Авлигатай тэмцэх дэлхийн форум”, “Зүүн Өмнөд Азийн Авлигатай тэмцэх бага хурал-Жакартагийн тунхаглалыг эргэн санах нь” арга хэмжээ, Бүсийн хөрөнгө буцаах байгууллагуудын сүлжээний 11 дэх уулзалт, авлигатай тэмцэх байгууллага хоорондын дэлхийн сүлжээ (GlobE)-ний 6 дахь Бүгд хурал, “Авлига ба татварын асуудлаарх Азийн бүсийн уулзалт”, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний (ACN) Бүгд хурал, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-ийн 2025 оны Жилийн хурал болон Техникийн туслалцаа, сургалтын форум, Ойрх дорнод, хойд Африкийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (MENA-ARIN)-ний Бүгд хурал, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (OECD)-ын Авлигын эсрэг сүлжээний Хууль сахиулагчдын сүлжээ (ACN LEN)-ний уулзалт, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын оролцогч талуудын бага хуралд албан хаагчид оролцлоо.

Хоёр. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030), түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, улсын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын болон хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах хяналт тавих, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлэхээр 122 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2024 оны хэрэгжилт 66,1 хувьтай үнэлэгдлээ. Хэрэгжилтээр нь авч үзвэл, 100 хувийн хэрэгжилттэй буюу “Үр дүнтэй” 30, 70,0-99,0 хувьтай хэрэгжсэн буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” 49, 30,0-69,0 хувьтай хэрэгжсэн буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” 34, 0-29 хувьтай буюу “Үр дүн-0” 9 арга хэмжээ байлаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлэхээр 122 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд ЗГХЭГ-тай хамтран Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2024 оны хэрэгжилт 66,1 хувьтай үнэлэгдлээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн болох үйл ажиллагааг үр дүнд чиглүүлэх, гүйцэтгэлийг хангах талаар санал санаачилгатай ажиллах, цаашид авах арга хэмжээний талаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий 128 байгууллагад зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 11 дүгээр зорилтын 11.1.2-т заасан “Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн хэрэгжилтийг үнэлэх, зөвлөмж өгөх, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийн хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 69 байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудтай уулзаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

• Хөтөлбөрийн Зорилго 1 (“Улс төрийн хүрээнд авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайлал, ил тод байдлыг төгөлдөршүүлнэ.”)-ийн 1.4.5-д заасан “Иргэдийн улс

төрийн боловсролыг дээшлүүлэн иргэд, сонгогчдын хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр Иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлнэ.” арга хэмжээний хүрээнд:

Хөтөлбөрийн зорилт 1.4.5-д заасан “Иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэн иргэд, сонгогчдын хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр Иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлнэ.” арга хэмжээний хүрээнд авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 2024 онд батлагдсан хөтөлбөрийг шинэчлэн жишиг хөтөлбөр болгож, аймаг, нийслэлийн ИТХ-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газарт хүргүүлснээр тус хөтөлбөрт тусгагдсан дэд хөтөлбөрүүдээс сонгон үйл ажиллагаандаа хэрэглэх боломжийг бүрдүүлэн, холбогдох заавар, зөвлөгөөгөөр ханган ажиллав.

Авлигын эсрэг иргэний нийгмийн эвслийн хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу “Авлигагүй гэрэлт нийгэм” ТББ-тай хамтран “Авлигын эсрэг иргэний эрхэм үүрэг” сэдэвт сургалтыг 6, 12 дугаар сард зохион байгуулж, 57 иргэнийг хамруулав.

“Эмэгтэйчүүд, залуучуудын оюуны сан” НҮТББ-тай хамтран “Авлигаас ангид нийтийн алба: Авлигын эсрэг төрийн албан хаагчийн манлайлал” сэдэвт ментор бэлтгэх 2 дахь удаагийн сургалтыг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагын удирдах түвшний давхардсан тоогоор 72 хүнийг хамруулж, хөтөлбөрөө амжилттай төгссөн 24 хүнд “ментор”-ын гэрчилгээ олгов.

Хөтөлбөрийн Зорилго 2 (Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ.)-ын Зорилт 2.3 буюу “Нийтийн албан тушаалтан зарлагаа мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын болон төрийн бусад мэдээлэлтэй уялдуулан хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.” зорилтын хүрээнд:

- “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль”-ийн төслийн төрийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлагыг тодорхойлсон 24 дүгээр зүйлийн 24.1.3 дахь заалтыг “сүүлийн 4 жил улс төрийн намын удирдах болон бусад албан тушаал хашиж байгаагүй, эсхүл улс төрийн албан тушаал хашдаггүй, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч биш байх” гэсэн агуулгаар өөрчлөн найруулах саналыг хууль санаачлагчид хүргүүлсэн.
- “Олон улсын стандартын академи” ХХК-тай хамтран “ISO 31000, ISO 37000 стандартын хэрэгжүүлэлт” сэдэвт сургалтыг зохион байгуулж “ISO 37001:2016-Авлигын эсрэг менежментийн тогтолцоо-дотоод аудитор” сертификатыг 10 албан хаагчид олгов. Сургалтын агуулгад “ISO 31000 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо”, “ISO 31010 Эрсдэлийн удирдлага-Эрсдэлийн үнэлгээний арга”, “ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо” стандартуудыг хэрэгжүүлэх талаар тусгаснаар авлигын эрсдэлийн үнэлгээнд ашиглаж болох аргууд, давуу болон сул байдлын талын талаар ойлголт, мэдлэг олгосон ач холбогдолтой сургалт боллоо.

АТҮХХАХТ-ний 2.6.1.3-д заасан “Үндэсний шударга байдлыг тогтолцооны суурь түвшин тогтоох судалгаа хийх” хүрээнд Үндэсний шударга байдлын тогтолцооны суурь түвшний үнэлгээ хийж, шударга байдлыг тогтолцооны 4 суурь, 13 тулгуур тулгуур багана болж буй хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглал, төрийн алба, хууль хяналтын байгууллага, сонгуулийн төв байгууллага, аудитын дээд байгууллага, авлигатай тэмцэх байгууллага, улс төрийн нам, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, хувийн хэвшил зэрэг 12 институцын үйл ажиллагааны бүрэн зураглалыг гаргаснаас гадна тэдгээрийн сул талыг илрүүлж, дотоод авлигын эрсдэл болон нийгэмд авлигатай тэмцэх чиглэлээр оруулж буй хувь нэмэр, гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхойлох ажлыг судалгааны болон иргэний нийгмийн байгууллагууд, зөвлөх баг, шинжээчидтэй хамтран гүйцэтгэв.

“Транспэрэнси Интернэшнл” байгууллагаас гаргасан аргачлалд зааснаар үнэлгээний тайланд тухайн асуудлаар мэргэшсэн хөндлөнгийн судлаачийн хараат бус санал, дүгнэлтийг тусгайлан авах ажлыг зохион байгуулах, 13 тулгуур баганын үнэлгээний тайлан, зөвлөмжийг хүлээн авч, олон нийтээр хэлэлцүүлэн тайланг баталгаажуулах ажил үргэлжилж байна.

-Зорилго 2-ын Зорилт 2.6 (Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга

хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.)-ын хүрээнд:

Шударга байдлын 2024 оны үнэлгээгээр хамгийн бага оноо авсан Боловсрол, шинжлэх ухааны яам (64,0), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (60,2), Ашигт малтмал, газрын тосны газар (58,7), Цаг уур, орчны шинжилгээний газар (61.5), Үндэсний геологийн алба (56,7), Баянхонгор (62,3), Дорнод (60,5), Завхан (65,6), Ховд (60,5), Сүхбаатар аймаг (59,7)-ийн Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтнуудтай уулзалт (цахим, танхим)-ыг удаа дараа зохион байгуулж “Шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх арга хэмжээний тусгайлсан төлөвлөгөө”-г батлуулж, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцаа, зөвлөгөө өгч, хяналт тавин ажиллалаа.

Шүүх, хууль хяналтын 9 байгууллагын хүрээнд хийгдсэн төсөөллийн судалгаагаар авлигын цар хүрээ “их” гэж үнэлэгдсэн шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний байгууллагуудад тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал,

Цагдаагийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-нд “Авлигын талаарх төсөөллийн судалгааны үр дүнг нэмэгдүүлэх” чиглэлээр тусгайлсан бүлэг тусгуулж, хэрэгжилтэд хяналт тавихын зэрэгцээ хамтран сургалт, хэлэлцүүлэг хийх зэрэг ажлыг зохион байгуулав.

Хөтөлбөрийн Зорилго 3 (Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ.)-ын хүрээнд:

Зорилт 3.3 (Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно.)-ын хүрээнд:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооноос “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэглэх этгээдийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, олон нийтийн хяналтыг дээшлүүлэх зорилгоор “Журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 04 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд тус тогтоолоор олон нийтийн хяналт хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааны чиглэлийг жил бүр тодорхойлох, хяналт хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, хамтран ажиллах, уг үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд зөвлөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг дарга нарт даалгасан.

“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор уг асуудлыг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий 21 аймаг, нийслэлийн 58 албан хаагчийг хамруулан чадавхжуулах цахим сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар журмыг танилцуулан, хяналтад хамруулах үйл ажиллагааг тодорхойлох, хяналт хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах талаар мэдлэг, мэдээлэл өгч, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангалаа.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газраас олон нийтийн хяналтад өгөх чиглэлийг тодорхойлох, хяналт хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажлыг эхлүүлсэн ба энэ хүрээнд нэгдсэн удирдлага, зааварчилгаагаар хангах viber групп нээн тогтмол мэдээллээр ханган ажиллаж байна. Тухайлбал, Архангай аймгийн Засаг даргын Тамгын газар “ЛАОС” ТББ-тай, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар “Эмэгтэйчүүд, залуучууд оюуны сан” ТББ-тай, Булган аймгийн Засаг даргын Тамгын газар “Гэрэлт ирээдүй оршихуй” ТББ-тай, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар “Чойр хөгжил” ТББ-тай, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар “Өрнөх хөгжил” ТББ-тай, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар “Эрдэнэт амьдралын тэмүүлэл” ТББ-тай, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар “Түмний түүчээ” ТББ-тай, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар “Хайр найдвар гэрэл” ТББ-тай, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар “Бид тусалъя” НҮТББ-тай хамтран дээрх журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хяналт хэрэгжүүлэгч иргэний нийгмийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан, мэдээллийг хүлээн авч, үр дүнг хэлэлцэж, туршлага солилцох уулзалт, сургалтыг 12 дугаар сард зохион байгуулав. Хяналт хэрэгжүүлэх хүрээнд идэвхтэй ажиллаж буй

байгууллагуудын туршлага солилцох, танилцуулах зорилгоор”Бодлогод залуусын хяналт” ТББ-тай хамтран “Дата эрх чөлөө: Олон нийтийн хяналт” сэдэвт үзэсгэлэнд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр ба Олон нийтийн хяналт, сайн туршлага” контент бэлтгэн ололцож, сурталчлах, олон нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, түүний ач холбогдол, иргэний хяналтыг хэрэгжүүлэх арга замуудын талаар оролцогчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх ур чадвар эзэмшүүлэх зорилгоор “Эмэгтэйчүүд, залуучуудын оюуны сан” ТББ-ын боловсруулсан “Авлигагүй нийгмийн төлөөх иргэний хяналт” сэдэвт 3 модуль бүхий сургалтын хөтөлбөр, модуль, гарын авлага болон иргэдийн улс төрийн боловсрол, сонгуулийн оролцооны талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд “Иргэний улс төрийн эрх, сонгуулийн оролцоо” 1 модульт сургалтын хөтөлбөр, гарын авлагад сайжруулалт хийж, гарын авлага, хөтөлбөрт үндэслэн сургалт зохион байгуулав.

Люксембург, Дани, БНСУ-ын Засгийн газрын дэмжлэгээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ХХ-ийн Санхүүжилтийн Цонх механизмаар дамжуулан хэрэгжүүлж байгаа НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр “Эрдэс баялгийн салбарт шударга байдлыг бэхжүүлэх Интегра” санаачилга болон “Хүний хөгжлийн төлөөх оролцооны арга замуудыг сайжруулах оролцоо” төслүүдийн хүрээнд зарласан тэтгэлэгт хөтөлбөрт шалгарч төслийг 2025 оны 8 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна.

Төрийн үйлчилгээний шударга, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэдийн оролцоог хангахад чиглэсэн энэхүү төслийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газраас Монгол Канадын гүүр” ТББ-аар гүйцэтгүүлсэн нутгийн захиргааны байгууллага болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ, 21 аймгаас ирүүлсэн энэ төрлийн 400 гаруй гэрээ, iltodgeree.mn сайтад байршсан 352 гэрээнд харьцуулсан дүн шинжилгээ хийлээ. Мөн Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлагдсан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний шинэчилсэн загварын төслийг боловсруулан хэлэлцүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэхэд бэлэн болгоод байна. Төсөл 2026 оны 2 дугаар сар хүртэл хугацаанд хэрэгжинэ.

“Глоб Интернэшнл” төвөөс ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан “Цахим эрин үе дэх хүрээлэн буй орчны талаарх мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах нь” сэдэвт үндэсний хэлэлцүүлэгт хамтрагчаар оролцов. Хэлэлцүүлгээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт туссан мэдээллийн ил тод байдлын зорилт, түүний хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэгт оролцогч төрийн байгууллага, салбарын төлөөлөл, судлаач, иргэний нийгмийн төлөөлөл, сэтгүүлчдийн дунд хэлэлцүүлж, цаашдын гарц, шийдлийг тодорхойллоо.

АТҮХ-ийн Зорилт 3.4.4-т заасан “Сэтгүүлчийн мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх” зорилтын хүрээнд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хүлээн авч шийдвэрлэсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийн, тайлан, зөвлөмж боловсруулах, 3.4.4.2-т тусгагдсан “Сэтгүүл зүйн бүтээл, редакцын ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэхэд иргэний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор таниулан сурталчлах ажлыг явуулах” арга хэмжээний хүрээнд мэдээлэл сурталчилгааны ажлыг гүйцэтгэж, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлэхээр Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран ажиллаж байна.

Хөтөлбөрийн Зорилго 4 (Хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлнэ.)-ийн Зорилт 4.1 (Бизнесийн ёс зүй, Компаенсын сайн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.)-ийн хүрээнд зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах зорилгоор Азийн хөгжлийн банк (АХБ)-д холбогдох саналыг хүргүүлснээр тус банкнаас тодорхой саналыг дэмжиж, 165 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. Энэ хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид авлигын эсрэг бодлого, стандарт, компаенсийн хөтөлбөр хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжих, урамшуулах хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах, түүний эдийн засаг, нийгмийн үр нөлөөний талаар судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг АХБ-д хүргүүлэв.

МҮХАҮТ-тай хамтран хувийн хэвшлийн байгууллагад хэрэгжүүлэх “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г шинэчлэн баталж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд компанийн

ёс зүйн дүрэм боловсруулах, түүнд дотоод шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах зохицуулалтыг тусгах талаарх зөвлөмжийг хүргүүлсний дээр тус Танхимтай хамтран “Компанийн дотоод орчинд шүгэл үлээх орчны талаарх өөрийн үнэлгээ хийх аргачлал”-ыг боловсруулаад байна.

АТҮХХАХТ-ний 4.1.2.1, 4.1.3.2-т заасныг хэрэгжүүлэх хүрээнд МҮХАҮТ, Монголын хөрөнгийн бирж, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлтэй хамтран авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулснаар банк, санхүү, уул уурхай зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй аж ахуйн нэгжийн 300 гаруй ажилтныг хамруулж, Стандарт хэмжилзүйн газартай хамтран "Комплаенсын менежментийн тогтолцоо ISO 37301", "Нийгмийн хариуцлагын ISO 26000" стандартыг нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөлд авлига болон нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэгт гэм буруутай нь тогтоогдсон бол компанийн удирдлагад ажиллуулахгүй байх саналыг хууль санаачлагчид хүргүүлэв.

Засгийн газар, яам, агентлагаас батлах дүрэм, журам, заавар, стандартын төслийг боловсруулахад иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, тэднээс санал авах, тусгах, хариу өгөх үйл ажиллагааг нэгтгэсэн цахим системийг бий болгох ажлыг эхлүүлэх, хэрэгжилтийг хангах, байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах талаар санал боловсруулаад байна.

АТҮХХАХТ-ний 4.2.4.8-д заасныг хэрэгжүүлэх хүрээнд “ISO37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо” стандартыг 2030 онд хүртэл хугацаанд төрийн өмчит 45 хуулийн этгээдэд нэвтрүүлэхээр төлөвлөснөөс “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Цемент шохой” ХХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Төрийн орон сууцны корпорац” ХХК, “МИАТ” ТӨХК, “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХК үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна.

Хөтөлбөрийн Зорилго 5 (Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж, аливаа нөлөөллийн эрсдэлийг бууруулна.), Зорилт 6.3 (Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар иргэдийн итгэл хүлээсэн шүүхийн тогтолцоог бэхжүүлнэ.)-ын хүрээнд:

Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран шүүгчийн 2025 оны сургалтын хөтөлбөрт авлигын эсрэг мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх агуулгатай буюу “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлж гаргасан нэхэмжлэл, анхаарах асуудал”, “Мөнгө угаах гэмт хэрэг”, “Хөрөнгө буцаах ажиллагаа” зэрэг сэдвүүдийг хөтөлбөрийн заавал болон сонгон судлах агуулгад тусгалаа. Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран бүсчилсэн сургалтыг Дархан-Уул, Дорнод аймагт тус тус зохион байгуулсан бөгөөд сургалтад Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн анхан болон давж заалдах шатны шүүх, Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүхийн 400 шүүгч, шүүхийн захиргааны ажилтан хамрагдав.

“Авлига, албан тушаалын гэмт хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх агуулга, хөтөлбөрийг шүүгчийн давтан сургалтад нэвтрүүлэх” зорилтын хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх талаар цогц мэдлэг олгох видео хичээлийн агуулгыг шинэчлэн боловсруулж байна.

Зорилт 5.5 (Авлигын эрсдэлийг тодорхойлж, хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлнэ.)-ын хүрээнд авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авлигыг таслан зогсоох зорилгоор үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд хийхээр төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажлын төсөв, санхүү, зарцуулалт, гүйцэтгэлийн авлигын эрсдэлд хөндлөнгийн хяналт тавьж, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал,

- БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-ийн удирдах хорооны дарга, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлсний дээр төслийн нэгжийн ажилтнуудад сургалт хийлээ. Түүнчлэн Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон холбогдох албан тушаалтнуудтай цахим уулзалт

хийж, төслийн ажилтнуудад хөндлөнгөөс нөлөөлөх, аль нэг хуулийн этгээдэд давуу байдал олгох зэргээр авлигын эсрэг хууль тогтоомжид заасан хориглолтыг зөрчихгүй байх талаар ярилцаж тухайн асуудлаар Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад зөвлөмж хүргүүлсэн. Дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд хэрэгжилт дунджаар 88,3 хувьтай буюу үр дүнтэй байлаа.

- Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал, Гэрээ, эрх зүйн газар, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын алба, Дамжуулах хоолой хариуцсан албаны дарга, Технологийн алба, Техникийн хяналтын албаны дарга нар болон Олон нийт хэвлэл хариуцсан ажилтныг оролцуулсан төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдах албан тушаалтнуудад дэд бүтцийн салбарт үүсэж болзошгүй авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, арга зүйгээр хангах зорилгоор уулзалт хийж, тодорхой асуудлаар санал солилцон мэргэжил аргазүйн зөвлөгөө өглөө.
- Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж байгаа “Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн чадавхыг сайжруулах төсөл”-д холбогдох баримтуудтай танилцан дүн шинжилгээ хийж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд тандалтаар ажиллав.
- Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барих төслийн нэгжийн эрх бүхий албан тушаалтнуудтай уулзаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч сургалт хийв.
- Азийн хөгжлийн банкны зээлээр Хөвсгөл, Хэнтий аймагт хэрэгжиж буй “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл” (Хөвсгөл, Хэнтий аймаг 2019-2026 он)-ийн 2025 оны төсөв, санхүү, зарцуулалт, гүйцэтгэлд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлийн хүрээнд судалж, дүн шинжилгээ хийлээ.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн хүрээнд хэрэгжиж байгаа “Улаанбаатар-Дарханы замд нэмэлт хоёр эгнээ барих төсөл”, БНХАУ-ын буцалтгүй 100 хувийн санхүүжилтээр бүтээн байгуулж буй “Ногоон нуур-1008 айлын орон сууц” төсөл, нийслэлд хэрэгжиж байгаа 7 мега төсөл болох “Улаанбаатарт их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” байгуулах”, “Улаанбаатар трамвай”, “Туулын хурдны зам”, “Шинэ тойрог зам”, “Дүүжин замын тээвэр”, “Тусгай замын автобус”, “Эрчим хүчний багц төсөл”-ийн менежер, ажилтнуудтай цуврал уулзалтууд хийж, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө, мэдээ, мэдээллийг тогтмол өгч ажиллаж байгаагийн зэрэгцээ холбогдох төслийн нэгж, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид зөвлөмж хүргүүлэв.

Хөтөлбөрийн Зорилго 6 (Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.)-ийн хүрээнд авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаарх өнөөгийн зохицуулалт, олон улсын туршлагын талаар судалгааг хийж, цаашид хэрэгжүүлэх саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Зорилго 7 (Төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулна.)-ын хүрээнд:

Төсөв, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний талаар Өвөрхангай аймгийн 45, Сүхбаатар дүүргийн 200 иргэнээс судалгаа авч, дүн шинжилгээ хийн төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгох, иргэний хяналт хэрэгжүүлэх талаарх санал, зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүллээ.

Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, үүсгэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг судлан эрсдэлийг үнэлэх, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлох зорилгоор “Эрүүл мэндийг дэмжих сан”-д ажиллан Эрүүл мэндийн сайдад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийлээ. Дүн шинжилгээгээр зөвлөмжийн үр дүн хангалтгүй байсан тул цаашид зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, авлигын эрсдэлийн түвшин 20,8 оноотой буюу “маш өндөр” гэж дүгнэлт гарсан, Үндэсний аудитын газраас 2021-2024 онд хийсэн аудитын тайлан,

дүгнэлтээр 4 жил дараалан “хязгаарлалттай” дүгнэлт авсан зэрэг нөхцөл байдалд анхаарч ажиллах талаарх зөвлөмжийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд хүргүүлэв.

Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд авлигын эрсдэлийн үнэлгээ хийх зорилгоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Баян-Өлгий, Өвөрхангай аймгийн болон Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст ажиллав. Тус салбар дахь авлигын эрсдэлийн түвшин “маш өндөр” буюу 21,1 оноотой дүгнэгдсэн бөгөөд авлигын эрсдэлийг үүсгэж байгаа суурь шалтгаан нөхцөл нь хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн томилгоо, ажил үүргийн хуваарилалт, албан хаагчдын удирдлагадаа үл итгэх байдал, үйл ажиллагааны нээлттэй бус байдал, хөндлөнгийн аудит болон хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, хариуцлага, хяналтын механизм сул байгаа зэрэгтэй холбоотой гэж дүгнэсэн.

Энэхүү илэрсэн нөхцөл байдалд үндэслэн эрсдэлийг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж ажиллах талаарх зөвлөмжийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад гардуулан өгөв. Зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг 2026 оны I улиралд багтаан ирүүлэх бөгөөд зөвлөмж тус бүрийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тусгайлан боловсруулах, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулахтай холбоотой байгууллага хоорондын ажлын уялдааг хангах чиглэлээр Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, холбогдох агентлагийн удирдлагатай уулзалт хийн нөхцөл байдлыг танилцуулж, хамтран ажиллах шийдлийн талаар ярилцлаа.

Авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудалд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллагыг иргэний нэхэмжлэгчээр тогтоох үндэслэл, шалтгааныг судлах хүрээнд холбогдох судалгааг хийж, авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоог сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулаад байна.

Зорилго 8 (Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн ил тод, үр ашигтай, хариуцлагатай хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.)-ын хүрээнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас боловсруулсан “Төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газрын засаглалыг үнэлэх нийтлэг аргачлал”-ын төсөлд санал хүргүүлж, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн ил тод, үр ашигтай, хариуцлагатай хяналтын тогтолцоог бүрдүүлэх талаарх судалгааг хийж, дүнд үндэслэн санал, зөвлөмжийн төслийг боловсруулаад байна.

. Зорилго 9 (Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна.)-ын хүрээнд:

Боловсролын ерөнхий газартай хамтран 26 их, дээд сургуулийн 209 багшаас авсан судалгаанд үндэслэн дээд боловсролын сургалтын байгууллагын авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээг хийлээ. Үнэлгээгээр энэхүү үйл ажиллагаа хангалтгүй түвшинд байгаа нь тогтоогдсон тул авлигыг үл тэвчих агуулгыг дээд сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгуулах санал, зөвлөмжийг боловсруулав.

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн боловсруулсан “Соён гэгээрүүлэх арга хэмжээний үр дүн, үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг үйл ажиллагаанд туршилтаар нэвтрүүлэн үр дүнд үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох ажил хийгдэж байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагын 25 сэтгүүлчийг хамруулан сургалт-хэлэлцүүлэг зохион байгуулж, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, авлигын төсөөллийн индекс, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар мэдээлэл хийлээ.

Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/137 дугаар тушаалаар Авлигыг үл тэвчих, шударга ёсны агуулга бүхий “Ёс суртахууны хариуцлага” сургалтыг дэмжих хөтөлбөрийг баталсантай холбогдуулан Боловсролын ерөнхий газар, Боловсролыг судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ухааны 623 багш нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

зорилгоор цахим сургалт-хэлэлцүүлгийг зохион байгуулж, энэхүү сургалтаар багш нарт тулгарч байгаа бэрхшээл, сургалтын үр дүн, сургалтыг сайжруулах боломж, аргачлалын талаар хэлэлцлээ.

Авлигыг үл тэвчих болон ёс суртахууныг төлөвшүүлэхэд шаардлагатай сургалтын агуулгыг бүх түвшний сургалтын хөтөлбөрт нэгтгэх зорилгоор сургалтын агуулгын матрицын загварын төслийг боловсруулаад байна.

Зорилго 9-ын Зорилт 9.2-т заасан Олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх зорилгоор үндэсний контентыг бүтээж, түгээх хүрээнд:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай хамтран өсвөр насны хүүхэд, залуучуудын нас сэтгэхүйн онцлог, сонирхолд нийцсэн, тэдний шударга ёсны талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэн, нийгэмд ёс суртахууны эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий үндэсний кино контентыг бүтээх ажлын хэсгийг байгуулж, хамтран ажиллалаа. Энэхүү хамтын ажиллагааны дүнд зохиолч Н.Уранзаяагийн зохиолоор, найруулагч М.Энхдалайн найруулсан “12ш” таван цуврал кино, контентыг бүтээж, нээлээ. Нээлтийн үйл ажиллагаанд Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 9, 12, 65 дугаар сургуулийн ахлах ангийн 130 сурагч, Хүүхэлдэйн театрын 45 залуу уран бүтээлч, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны 3, нийт 178 хүнд оролцсон бөгөөд “Ес зүйтэй залуу үе” илтгэл хэлэлцүүлж, сурталчилгааны материалыг түгээх зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх газрын захиалгаар 2020 онд хүүхдийн зохиолч Н.Мандалын зохиосон зохиолоор Хүүхэлдэйн театрт хамтран найруулагч М.Ариунтуяагийн найруулсан “Хаалган хадны нууц” нэртэй хүүхэлдэйн оролцоот хүүхдийн жүжгийг Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн 1, 2, 3 дугаар суваг, “Гэр бүл” сувгаар 4 удаа нэвтрүүлж, олны хүртээл болгов.

Шударга ёсны төлөөлөл бүхий “Баатар”-ын дүрийг тодорхойлох, виртуал дүр бүтээх ажлын хүрээнд хиймэл оюун ухаанд суурилсан виртуал аватар ашиглан олон төрлийн контент бүтээх боломжийг эрэлхийлж энэ чиглэлд үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшил, төслийн багуудтай хамтран ажиллалаа. Хүүхдэд зориулсан шударга ёсны дүр төрх болох 3D “Шударга аагий /мазаалай/”, 3D “Шударга унага”, иргэд олон нийтэд зориулсан шударга ёсны дүр төрх болон Авлигатай тэмцэх газрын хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах эрэгтэй, эмэгтэй ажилтны дүр төрхийг гаргах, үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлэхээр төслийг боловсруулах ажил хийгдэж байна.

ТАЗ-ийн дэргэдэх Ёс зүйн хороо, Стандарт, хэмжил зүйн газар, Үндэсний статистикийн хороо, Эрчим хүчний зохицуулах хороо, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Боловсролын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Усны газар, Ойн газар, Цаг уур, орчны шинжилгээний газар, Стандарт, хэмжил зүйн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Нийслэлийн болон Хан-Уул, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймгийн Засаг даргын Тамгын газар, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв болон тус дүүргийн Нийгмийн даатгалын газар, Хилийн цэргийн 0218-р анги, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ, “Е-Mongolia академи” УТҮГ, “Нээлттэй нийгэм форум” ТББ зэрэг нийт 57 байгууллагатай хамтран авлигын хор хөнөөлийг ухуулан таниулсан болон авлигаас урьдчилан сэргийлэх агуулга бүхий нийт 193 контент болон богино хэмжээтэй Reel видеог бүтээж дээрх байгууллагуудын цахим хуудас, Авлигатай тэмцэх газрын “Олон нийтийн төв” пейж хуудас болон бусад пейж хуудсаар олон нийтэд түгээсэн бөгөөд давхардсан тоогоор нийт 127 300 742 хүнд хүрсэн байна.

Зорилт 9.4 (Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшлийг дэмжинэ.)-ийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Боловсролын газартай хамтран хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэх ажил арга хэмжээний талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Соёл урлагийн газар, Боловсролын ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Нийслэлийн боловсролын газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Монголын сурагчдын холбоо ТББ, Эцэг эхийн үндэсний зөвлөл ТББ, Боловсрол хамтын

ажиллагааны нийгэмлэг ТББ, Нийслэлийн 12 дугаар сургууль зэрэг байгууллагуудын төлөөллүүд оролцож, холбогдох асуудлаар мэдээлэл солилцон, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцлээ.

Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийн дүн шинжилгээнд үндэслэн бууруулах арга хэмжээ авах зорилгоор нийслэлийн ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн 3 дугаар ангийн 40 сурагч, Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 11 дүгээр ангийн 160 сурагчийг хамруулан “Шударга байх хамгийн гоё” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан нь сурагчдын сонирхлыг татсан, сурагчид идэвхтэй оролцсон, тэдний шударга ёсны талаарх мэдлэг, мэдээллийг бататгасан арга хэмжээ боллоо гэж үзэж байна.

Боловсролын сургалтын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн “Шударга ёсны клуб”-ийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх, сөрөг зан суртахуун, нөлөөллөөс хамгаалах зорилго бүхий “Сайн иргэн” аяныг “Монголын сурагчдын холбоо” ТББ-тай хамтран зохион байгууллаа. Аяны хүрээнд сурагчдын өөрсдийн санаачилгыг дэмжин нийслэлийн 55 сургуулийн төлөөлөл 150 орчим сурагчдыг оролцуулан “Шударга ёсны андгай” өргөх арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд арга хэмжээнд үндэслэн нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хичээл эхлэхийн өмнө “Шударга ёсны андгай”-г уншиж хэвшүүлэх ажиллагааг туршилтаар хэрэгжүүлж эхлээд байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба зэрэг байгууллагуудын оролцоонд тулгуурлан “Хүүхдэд ээлтэй шүүх” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд болон ахлах ангийн 300 орчим сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, сургуулийн орчин дахь шударга байдлыг нэмэгдүүлэх, үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох, ирээдүйн мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэх агуулга бүхий сургалтад хамруулав.

Боловсролын ерөнхий газрын Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний газартай хамтран мэргэжлийн болон техникийн боловсролын сургуулийн хөтөлбөрт ёс зүйн агуулга тусгасан байдлын талаарх судалгаа хийж, үр дүнгийн талаар Насан туршийн боловсролын хэлтэс, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний газар, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн иргэний ёс зүйн боловсрол, нийгэм судлалын болон мэргэжлийн багш нар, сургалтын арга зүйч нийт 45 оролцогчийг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгээс мэргэжлийн болон техникийн боловсрол, Насан туршийн суралцахуйн төвийн сургалтын хөтөлбөрийн агуулгад авлигыг үл тэвчих, ёс зүй, хариуцлагын асуудлыг тусгах талаар санал солилцов.

Зорилт 9.5-д заасан “Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах” хүрээнд шүгэл үлээхийг дэмжих хамгаалалтын арга хэлбэрийг байгууллагын дотоод журамд тусгах зөвлөмжийг хүргүүлснээр ажил олгогчдоос холбогдох журамд энэхүү асуудлыг тусгаж эхлээд байна. “Авто радио 96,3”-ийн “5 асуулт” подкастаар дамжуулан “Шүгэл үлээгчийн талаарх ойлголт, шүгэл үлээх ач холбогдол”-ын талаар видео контент бүтээж, олон нийтийн цахим сүлжээгээр түгээж олон нийтийн хүртээл болголоо.

Гурав. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар

3.1. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсэгт заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн хүрээнд доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Төрийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх ажлыг зохион байгуулав. Төлөвлөгөөг хэрэгжүүлбэл зохих төрийн захиргааны нийт 91 байгууллагын өөрсдийн дундаж үнэлгээ 95,6 хувь, Авлигатай тэмцэх газраас хийсэн хөндлөнгийн үнэлгээний дунджаар 66,6 хувьтай үнэлэгдэв.

Иймд авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол ханган, зөвлөмж хүргүүлсний дээр тайлагнах хугацааг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн цагалбартай нийцүүлэх, төрийн байгууллагуудад олон төрлийн давхардсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхээс зайлсхийх зорилгоор тухайн байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагаанд төлөвлөгөөнд шударга байдлын түвшин болон авлигын талаарх төсөөллийн судалгааны үр дүнг нэмэгдүүлэх асуудлыг тусгайлсан бүлэг болгон нэмж тусгуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч, нийт 92 байгууллагын төлөвлөгөөнд баталгаажуулалт хийлээ.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Шударга байх хамгийн гоё” өдөрлөгийг Сүхбаатарын талбай, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн сурын талбай, Сонгинохайрхан дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн “Эрдэм төв”-ийн асрамжийн газарт тус тус зохион байгуулав. Өдөрлөгт 7000 гаруй хүн хамрагдсан ба арга хэмжээг зохион байгуулах явцад эцэг, эхчүүдтэй фокус ярилцлага хийх, гэр бүлийн түвшинд хүүхдийн хүмүүжил, төлөвшилд шударга байх, шударга бус явдлын талаар тайлбарлах, ойлгуулах, нөхөрсөг тусч байх, хүнлэг байх талаар ярилцах хэлбэрээр зохион байгуулсан ба байгууллагын үйл ажиллагааг сурталчлан, ном, гарын авлага, материалыг түгээлээ.

Хуулийн чиглэлээр суралцаж байгаа оюутан, залуус болон судлаачдын авлигын гэмт хэргийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хууль хэрэглээний чадварыг дээшлүүлэх зорилгоор Өмгөөллийн “Алтаргана хуулийн товчоо” болон Боловсролын ерөнхий газар, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар, ДХИС-ийн Цагдаагийн сургуультай хамтран “Mock Trial 2025” эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг зохион байгуулав.

Тус тэмцээнд МУИС, ДХИС-ийн Цагдаагийн сургууль, Шихихутуг их сургууль, Их засаг олон улсын их сургууль, Отгонтэнгэр их сургуулийн нийт 16 багийн 96 оюутан, 4 чиглүүлэгч багш нар оролцсон ба уг тэмцээн шүүхийн бодит танхим болон цахим хэлбэрээр явагдсанаараа онцлог арга хэмжээ боллоо. Тэргүүн байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “SUITS” баг, Дэд байранд Шихихутуг их сургуулийн “INFERNO” баг, Гутгаар байранд ДХИС-ийн “МӨРЧ” баг, Тусгай байранд Отгонтэнгэр их сургуулийн “ОТИС” баг шалгарч, Шилдэг итгэгчээр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “SUITS” багийн гишүүн тодорлоо.

Ерөнхий боловсролын 1, 12, 24, 40, 84 дүгээр сургуулийн “Шударга ёсны клуб”-ын 9-12 дугаар ангийн идэвхтэн 50 сурагчийг хамруулан сургуулиас гадуурх сургалтын “Санрайс холбоо” ТББ-тай хамтран өсвөр үеийнхний зөв харилцаа хандлага, багаар ажиллах чадвар, өөртөө итгэлтэй, шударга, хариуцлагатай байх чадварыг нэмэгдүүлэх, бүтээлч аливаа зүйлд сэтгэлээсээ хандах чадавхтай, сурах хөгжих тэмүүлэлтэй болох сэдлийг төрүүлэх зорилгоор сургалтыг зохион байгууллаа.

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгааны ажлыг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллээр хангаж, сурталчилгааны материалуудыг түгээлээ. Тус арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 7788 иргэн хамрагдав.

3.2. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;” чиг үүргийн хүрээнд:

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нарт Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд болон “Сургагч багш”-ыг авлигын эсрэг олон нийтийн соён гэгээрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийн захиран зарцуулалт, худалдан авах ажиллагаа, тусгай зөвшөөрөл, албан

тушаалын томилгоотой холбоотой ашиг сонирхлын зөрчил үүсэх, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх талаар үүрэг хүргүүлээ.

Дээрх үүргийн биелэлтийг хянах хүрээнд Булган, Баянхонгор, Дархан-Уул, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар аймгийн болон Нийслэлийн Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс ирүүлсэн тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийгээд байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгт хамаарах ажил, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хүргүүлэв.

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2025 онд авлигын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлууллаа. Төлөвлөгөөнд тусгагдсан тус байгууллагын хариуцан хэрэгжүүлбэл зохих ажил арга хэмжээний хувьд:

- “Иргэдийн үзэл бодол” асуулт хариулт бүхий цуврал видео контент бүтээх, түгээх ажлын хүрээнд 18 цуврал видео хийж, байршуулан олон нийтэд түгээсэн;
- “Өдрийн сонин”-д “Авлигын эсрэг залуусын дуу хоолой” буланг үүсгэж, нийт 15 дугаарыг 7 хоногт 2 удаа тогтмол давтамжтайгаар хөтлөн нийтлэв;
- Төрийн байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг “Зөв хүүхэд” сургалтын сургагч багшаар бэлтгэх сургалтыг “Дуду Зоне” ХХК-тай хамтран “Teamwork & Teamplay Mongolia” хөтөлбөрөөр зохион байгуулж, Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн боловсролын газар, Чингэлтэй дүүргийн ЗДТГ, Налайх дүүргийн ЗДТГ, Нийслэлийн боловсролын газар, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Нийслэлийн ерөнхий боловсролын 1, 12, 84, 24, 65, 32 дугаар сургуулиудын эцэг, эхийн зөвлөлийн гишүүн, “Шударга ёсны клуб”-ын чиглүүлэгч багш нарын зэрэг нийт 20 хүнийг хамрууллаа;
- Нийслэлийн прокурорын газартай хамтран гааль, татвар, газар, цагдаа, улсын бүртгэл, боловсрол, эрүүл мэнд, шийдвэр гүйцэтгэлийн болон зэвсэгт хүчин, Автотээврийн үндэсний төвийн зэрэг нийтдээ 1300 орчим ажилтан, албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгууллаа;
- Нийслэлийн прокурорын газартай хамтран “Авлигын гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж зөвлөмж гаргав;
- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий 2 төрлийн видео шторк, 1 контент, 8 зурагт хуудсыг хэвлүүлээд байна.

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 40, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 32 төлөөлөгч, тус дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг төрийн 205 байгууллагын 501 албан хаагчийг хамруулан “Шударга нийгмийн төлөө хамтдаа” сургалт-өдөрлөгийг зохион байгууллаа.

Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 65 дугаар сургуульд ерөнхий боловсролын сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчээс албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээг дагаж мөрдөх, багшийн мэргэжлийн нэр хүндийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, сургууль болон гэр бүлээр дамжуулан сурагч, эцэг эх, багш нарт авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад туслах зорилго бүхий “Шударга ёсны клуб”-ыг шинээр байгуулснаар 2025 оны байдлаар 13 клуб үйл ажиллагаа явуулж байна.

3.3. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх хэсэгт заасан “төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах,” чиг үүргийн хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд

нийт 107 төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Тухайлбал,

- “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ, “Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ, “Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-тай хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлж, 4 удаагийн сургалтад 197 хүнийг хамруулав.
- Барилгын зураг төсөл зохиогчдын мэргэшлийн зэрэг горилогч, сунгагчдад зориулсан сонгон судлах сургалтын хөтөлбөрт “Авлигын хор хөнөөл” сэдэвт хичээлийг тусгаж, кредит цаг тооцдог боллоо.
- Сургуулиас гадуурх сургалтын “Санрайс холбоо” ТББ-тай хамтран өсвөр үеийнхний зөв харилцаа хандлага, багаар ажиллах чадвар, өөртөө итгэлтэй, шударга, хариуцлагатай байх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн сургалтыг зохион байгуулав.
- “Монголын үндэсний зуслангуудын холбоо” ТББ, Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбортой хамтран зусланд амарч байгаа хүүхдүүдэд зориулсан “Шударга ёсонд суралцъя” хөтөлбөрийг боловсруулж, туршилтын журмаар нэвтрүүлээд байна.
- Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, “Монголын оюутны холбоо” НҮТББ-тай хамтран оюутан, залуусыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хөгжлийн бодлогод оролцоо, манлайллыг хангах зорилго бүхий “Оюутны менторшип” тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүллээ.
- “Монголын байгаль орчны иргэний зөвлөл” ТББ-тай хамтран байгалийн нөөц ашиглалтад авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан.
- “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ, “Монголын хараагүйчүүдийн холбоо” ТББ-тай хамтран өдөрлөг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааг танилцуулж, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл гаргах, түүнийг хүлээн авах журмын талаар мэдээлэл өглөө.
- “Зөвийг шүгэлдэгчид” ТББ-тай хамтран “Залуучууд ирээдүйг зурна” сургалт, өдөрлөг, Монголын өмгөөлөгчдийн холбоо” ТББ-тай хамтран иргэдэд зориулсан “Өмгөөлөгч-Танд тусалъя” нээлттэй өдөрлөг, Дарханы мэтгэлцээний нэгдсэн танхим” ТББ-тай хамтран “Мэтгэлцээний тэмцээн”, “Нээлттэй нийгэм форум”-тай хамтран “Монгол Улсын Засгийн газар болон Улаанбаатар хотын мега төслүүдийн тойм зураглал” төслийн ажлыг танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгууллаа.
- “Эрүүл мэндийн чанарын холбоо” НҮТББ, “Монголын Криминологичдын холбоо” НҮТББ-тай хамтран авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг хийлээ.

3.4. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2 дахь хэсэгт заасан “авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах” чиг үүргийг хангах хүрээнд:

Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны А/183 дугаар “Заавар батлах тухай” тушаалаар баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ын дагуу нийт 17 салбарт хамаарах 257 шийдвэр, дүрэм, журмыг хянаж, тухайн дүрэм, журмыг бүхэлд нь хүчингүй болгох, хуульд заасан шаардлага хангуулах саналыг хүргүүлснээс эрх бүхий байгууллагаас 101 захиргааны хэм хэмжээний актыг бүхэлд нь хүчингүй болгож, 6 актын холбогдох хэсгийг хүчингүй болгон шийдвэрлэсэн дүнтэй байна.

Авлигын эсрэг хуулийн 6.1.9 дэх хэсэгт “Төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймаг, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, “Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн” ОНӨҮГ, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Эрдэнэт Булганы

цахилгаан түгээх сүлжээ”, “Монголын хөрөнгийн бирж”, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ”, “Баянзүрх дүүргийн хөгжлийн төв” зэрэг 11 байгууллагын ёс зүйн дүрмийн төсөлд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг тусгах, авлигаас ангид, шударга байх хэм хэмжээг тусгах талаарх холбогдох саналыг хүргүүлэв.

3.5. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь хэсэгт заасан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” чиг үүргийн хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:

2025 онд авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор нийт 610 удаагийн сургалтад 41999 хүнийг, төрийн байгууллагад 430 удаагийн сургалтад 27725 хүнийг, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 71 удаагийн сургалтад 4210 хүнийг, хувийн хэвшлийн байгууллагад 53 удаагийн сургалтад 5828 хүнийг, төрийн бус байгууллагад 33 удаагийн сургалтыг зохион байгуулж 1981 хүнийг, оюутан, залуус, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан 23 удаагийн сургалтад 2255 сурагч, сурган хүмүүжүүлэгч нарыг хамруулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, зохион байгуулсан сургалтын тоо 13.3 хувиар, сургалтад хамрагдсан хүний тоо 13.9 хувиар өссөн дүнтэй байна.

Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах үйл ажиллагаандаа татан оролцуулах зорилгоор сургагч багш бэлтгэх сургалтыг төрийн 50 байгууллагын 117 албан хаагчийг оролцуулан зохион байгуулж, гэрчилгээ олголоо. Сургагч багш нарын дунд цахимаар холбоос үүсгэн мэдээлэл, арга зүйн зөвлөгөө дэмжлэгийг тогтмол өгч хамтран ажиллаж байна.

Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлын хүрээнд “Сургамжит өгүүллэг”, “Чимээгүй үнэн” ном, “Муу нөхөр”, “Эвтэй дөрвөн амьтан” буддаг ном, “Шударга ёс сэтгэхүй хөгжүүлэх бодлого”, “Зөв зөвд шударга зөв” зэрэг 12 төрлийн ном, гарын авлага, 26 төрлийн сурталчилгааны материал хэвлүүлж түгээн, сурталчилгааны дэлгэц болон facebook-т зориулсан 22 баннер, 9 постер, 25 reel видео, 13 шторк, контент хийж сурталчилгаанд ашиглалаа.

Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус 57 байгууллагатай хамтран авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий 193 контент болон богино хэмжээтэй reel видео бүтээж, төрийн болон төрийн бус байгууллагуудын цахим хуудас, Авлигатай тэмцэх газрын “Олон нийтийн төв” пейж хуудас болон бусад олон дагагчтай пейж хуудсаар олон нийтэд түгээх ажлыг тасралтгүй хийж байна.

Радиогийн нэвтрүүлгээр дамжуулан иргэдийн авлигын эсрэг мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, иргэдийн оролцоог хангаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөлийг танин мэдүүлэх зорилгоор “Дэлхийн монголчуудын радио-“MGL” радиотой хамтран “Нэг дусал” контентыг нэг удаад 3 минут үргэлжлэхээр бэлтгэн өдөрт 9 удаагийн давталтайгаар, 70 сэдвийн хүрээнд холбогдох контентыг, “Авто радио 96,3”-аар сар бүр 10, нийт 40 сэдвээр, түүнчлэн “110 чөлөөт подкаст”-ын 4 дугаар, “5 асуулт видео подкаст”-ын 9 дугаарыг тус тус бэлтгэн олон нийтийн хүртээл болголоо.

МҮОНТ-тэй хамтран 14 хоног тутам “Авлигатай тэмцэх газрын мэдээлэл” нэвтрүүлгийг 20 минутаар бэлтгэн тогтсон цагт олон нийтийн хүртээл болгож байгаа бөгөөд нийт 22 удаагийн дугаарыг тодорхой сэдвээр бэлтгэн МҮОНТ-ийн 1, 2 дугаар суваг, “UBS”, “LIVE”, “TB-24” телевиз болон байгууллагын фэйсбүүк, пейж хуудсаар олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав. “TB-5” телевизтэй хамтран эрхлэн хэвлүүлсэн ном, гарын авлагыг сурталчлах, сургуулийн өмнөх насны хүүхдэд шударга байдлыг төлөвшүүлэх зорилгоор 20 минутын тусгай нэвтрүүлэг бэлтгэж, “Шидэт харандаа” нэвтрүүлгээр 24 удаагийн давтамжтайгаар олон нийтийн хүртээл болгон ажиллалаа.

Авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор сурталчилгааны материалыг бүхий л төрлөөр хэвлэн түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулснаар 12 төрлийн ном, гарын авлагыг боловсруулан, 26 төрлийн сурталчилгааны материалыг хэвлүүлж, түгээв.

3.6. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв.

Авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөл, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр давхардсан тоогоор 79 байгууллагад 85 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, 9 яам (*Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Зам, тээврийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам*), Засгийн газрын 18 агентлаг, түүний харьяа байгууллагууд (*Стандарт, хэмжил зүйн газар, Гаалийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар түүний харьяа Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, Мал эмнэлгийн ерөнхий газар, түүний харьяа Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Иргэний нисэхийн ерөнхий газар, Соёл урлагийн газар, Ашигт малтмал газрын тосны газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Ус сувгийн удирдах газар, Ойн газар, Туул голын сав газрын захиргаа, Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Цөмийн энергийн комисс, 10 хуулийн этгээд буюу Эрдэнэс Монгол ХХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Монгол кино нэгтгэл ТӨҮГ, Батлан хамгаалах яамны харьяа Бөртэ ТӨААТҮГ, Радио телевизийн үндэсний сүлжээ ТӨҮГ, МИАТ, Улаанбаатар төмөр зам, Гашуун сухайт авто зам, Авто тээврийн үндэсний төв, Монголын төмөр зам*), нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны 20 байгууллага (*Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Нийслэл, Архангай, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Завхан, Орхон, Өмнөговь, Ховд, Увс, Сэлэнгэ аймгийн Засаг дарга нар, Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Ус сувгийн удирдах газар, Сонгинохайрхан дүүргийн Боловсролын Хэлтэс*), эрүүл мэндийн салбарын 11 байгууллага (*Цэргийн төв эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв*) болон “Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих, Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн нэгж зэрэг байгууллагуудад хүргүүлсэн.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн 42 зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, авлигын эрсдэлийг тогтоох, шалтгаан, нөхцөлийг арилгах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хүнд суртал чирэгдлийг бууруулах чиглэлээр 24 төрийн байгууллага, албан тушаалтанд шаардлага хүргүүлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авхуулахаар хүргүүлсэн мөрдөгчийн 76 мэдэгдэл, 41 албан бичгийн, үүнээс 28 мэдэгдлийн мөрөөр газар дээр нь ажиллаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байхад чиглэсэн зөвлөмж хүргүүлэх, мэдээлэл арга зүйгээр удирдлагаар хангах, сургалт хийх зэргээр хамтарч ажиллах, авлигын эсрэг сурталчилгааны материал түгээх зэргээр ажиллаж байна.

3.7. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т заасны дагуу авлигын эрсдэл, шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, эрсдэлийн түвшнээс хамааран урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг ялгавартай тогтоож, багц арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, Засгийн газрын сан, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нийт 156 байгууллагын үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал байгаа эсэхийг тогтоох, мөн энэ төрлийн зөрчил дутагдлыг арилгуулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор газар дээр нь ажиллалаа. Энэ хүрээнд 40 байгууллагад зөвлөмж, 10 байгууллагад шаардлага, 12 байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч, 3 байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгууллаа.

Дөрөв. Судалгаа шинжилгээний ажлын чиглэлээр

Авлигын эсрэг хуульд заасан чиг үүрэг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын болон зорилтот судалгааны ажлуудыг гүйцэтгэхийн зэрэгцээ Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасныг үндэслэн авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийхэд төрийн бус байгууллагуудыг оролцуулах зорилгоор зарим судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Тайлант хугацаанд:

- “Шударга байдлын үнэлгээ-2025” судалгааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр шалгарсан “Бодлогын шийдэл” ХХК-ийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангаж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллалаа. Судалгаанд төрийн 81 байгууллага хамрагдсанаас Мал эмнэлгийн ерөнхий газар, Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, Архангай, Дархан-Уул, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын шударга байдлын үнэлгээний үзүүлэлт 10.3-1.2 оноогоор буурч, Баянхонгор, Ховд, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын мөн үзүүлэлт 2024 онтой харьцуулбал өөрчлөлтгүй байгаа дүн гарлаа.

Цаашид төрийн байгууллагын авлигын шалтгаан, нөхцөл, үйлчилгээний чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг бодитойгоор тогтоож, цаашид авлигын эсрэг үйл ажиллагааг илүү үр нөлөөтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор өмнөх онуудад хийгдсэн судалгааны үр дүнд харьцуулсан дүн шинжилгээ хийх замаар төрийн байгууллагуудын шударга байдлын түвшингийн чиг хандлага, давтамж, эрсдэлийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлох ажлыг гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

- “Хүүхдийн шударга байдал-2024” оны судалгааны үр дүнг боловсролын салбарын төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулиуд болон хүүхдийн боловсрол, хүмүүжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллүүд оролцуулан хэлэлцүүлж, хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, ажил, арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил хамтран ажиллах санал, санаачилгыг дэвшүүлж, нөхцөл боломжийг тодорхойлов.

- “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”-ны ажлыг гүйцэтгэсэн “Хөгжлийн санаачлага, бодлого судлалын төв” НҮТББ-д мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллалаа.

Судалгаанд нийт 780 респондент хамрагдсан бөгөөд оролцогчдын 51.5 хувь нь сүүлийн 2 жилийн хугацаанд авлигын түвшин нэмэгдсэн гол шалтгааныг төр болон бизнесийн ашиг сонирхол давхацдаг, институцийн хариуцлагын тогтолцоо сул, хууль хяналтын байгууллага авлигад өртөмтгий байгаа талаар онцолж, авлигын түвшинг бууруулахын тулд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хөрөнгө орлогын мэдүүлгийн хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгах, төрийн үйлчилгээг цахимжуулж ил тод байдлыг нэмэгдүүлэх нь үр нөлөөтэй гэж үзсэн байна.

Иймд авлигатай тэмцэх эрх зүйн орчин, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хууль, баримт бичигт дүн шинжилгээ хийх, бодлогын санал боловсруулах, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-аас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал /2024–2027/” төслийн хоёрдугаар хөтөлбөрийн хүрээнд “Олон нийтийн төслийн судалгаа”-г өргөтгөн зохион байгуулахаар төлөвлөөд байна.

- “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаа”-г гүйцэтгэлээ. Тус судалгааг гүйцэтгэхээр шалгарсан “Модун хөгжлийн төв” НҮТББ-ыг холбогдох мэдээ, мэдээллээр ханган, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллав. Судалгаанд хувийн хэвшлийн 350 аж ахуйн нэгж хамрагдсан бөгөөд судалгаанд оролцогчдын 26.3 хувь нь төрийн албаны авлигын хэмжээг “маш их” гэж үнэлснийг 2018 онд хийгдсэн энэ төрлийн судалгааны мөн үзүүлэлттэй харьцуулахад 17.9 хувиар, 28.8 хувь нь “тодорхой хэмжээнд” гэж үнэлсэн нь 2018 оныхоос 12.1 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй гарлаа.

- Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-аас чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэлийг тодорхойлох, Авлигатай тэмцэх газраас баримталж байгаа бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг хянах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах зорилгоор судалгааг 586 ЭБАТ-ыг хамруулан хийж, судалгааны дүнд

үндэслэн ЭБАТ-уудыг чадавхижуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах зэрэг ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.1.1-д заасан “Салбар дахь үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх аргачлал боловсруулж, үнэлгээ хийх” арга хэмжээний хүрээнд уул уурхайн салбарын авлигын эрсдэлийг бодитой үнэлэх, хариу арга хэмжээ авах бодлого, үйл ажиллагааг оновчтой тодорхойлох, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үнэлгээний аргачлал боловсруулах ажлыг гүйцэтгэсэн “Сэргэлт Консалтинг Групп” ХХК-тай, мөн “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг шинэчлэн боловсруулах ажлыг “Хөгжлийн зүгт” ТББ-тай хамран гүйцэтгэлээ. Уул уурхайн салбар дахь авлигын эрсдэлийг үнэлэх аргачлалын төсөлд уул уурхай салбар дахь бүх шатны үйл ажиллагаанд үүсэх авлигын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, бууруулахад чиглэсэн бүтэц, шалгуур үзүүлэлт, институцийн харилцан хамаарлыг тусган, уул уурхайн салбарын төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл, судлаач шинжээч нарыг, “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг боловсруулахад гадаад, дотоод шударга байдлын үнэлгээ бодлогод оролцогчдын үнэлгээний асуумж хэлбэрээр талуудын оролцоог ханган зохион байгууллаа. Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг төсөлд тусган санал авахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтан, оролцогч талуудад хүргүүлээд байна.

• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд авлигын эрсдэл, шалтгаан, нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, худалдан авах ажиллагааны зардал, санхүүжилтийн эх үүсвэр, худалдан авах мөчлөгийн үе шат бүрд (шаардлага тодорхойлох, тендер шалгаруулалт, үнэлгээ, гэрээний хэрэгжилт зэрэг) үүсэх эрсдэлийн хүчин зүйлсийг судлав. Мөн төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системийн үйл ажиллагаа, ил тод байдлыг үнэлж, Авлигатай тэмцэх газар, Сангийн яам, Монополын эсрэг газарт 2020-2023 онд худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийн тайланд дүн шинжилгээ хийж, тайланг боловсруулаад байна.

“Шударга ёс” онол, арга зүйн цуврал сэтгүүлийн 2025 оны эхний хагас жилийн дугаарыг хэвлүүлэн түгээж, 2 дахь дугаарыг хэвлэлтэд шилжүүлээд байна.


Тав. Хяналт шалгалт, дүн шинжилгээний ажлын талаар:

5.1. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас ХАСХОМ-ийн талаарх тайлан, мэдээг хүлээн авч, нэгдсэн дүн мэдээг гаргалаа.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2025 оны 02 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 130 байгууллагын 48841 (цахим-45630, хэвлэмэл байдлаар-3211) мэдүүлэг гаргагч мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлж, баталгаажуулсан. Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон түүнтэй адилтгах 220 албан тушаалтнаас 204 албан тушаалтан буюу 100 хувь хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлсэн байна. (16 албан тушаалын орон тоо сул байсан.)


Мэдүүлэг гаргагчдын 12441 буюу 26.5 хувь нь төрийн захиргааны, 15202 буюу 31.1 хувь нь төрийн тусгай, 8119 буюу 16.6 хувь нь улс төрийн, 7341 буюу 15.0 хувь нь төрийн үйлчилгээний удирдах, төрийн өндөр албан тушаалтан, тэдгээртэй адилтгах 204 буюу 0.4 хувь нь, 4447 буюу 9.1 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах, 1087 буюу 2,2 хувийг бусад албан тушаалтнууд эзэлж байна.

Дүрслэл 1. ХАСХОМ мэдүүлсэн албан тушаалтан
(төрийн албан тушаалын ангиллаар, өмнөх онтой харьцуулснаар)



Нийт мэдүүлэг гаргагчийн 26905 буюу 54.1 хувь нь Улаанбаатар хотод, 21936 буюу 45.9 хувь нь орон нутагт байна. Орон нутгаас Хөвсгөл аймгаас 1394 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн нь бусад аймгуудаас өндөр үзүүлэлт болж байна.

Дүрслэл 2. ХАСХОМ мэдүүлсэн мэдүүлэг гаргагчийн тоо
(аймгаар)



УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2024 оны “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах” 5 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д өөрчлөлт оруулснаар нийт мэдүүлэг гаргагчдын тоо өмнөх оноос 1417 нэгжээр буурсан байна.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын 852 албан тушаалтан “хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлж, 39908 албан тушаалтан “тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл”, 237 нь “ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан байна.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийт мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор Төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2024 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.hasxom.iaas.mn> цахим хуудсанд 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр нээлттэй байршуулж ил тод нээлттэй мэдээллээ.

5.2. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан талаар: Тайлант хугацаанд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн өмнөх оны үлдэгдэл 411, 2025 оны 19203, нийт 19614 этгээдийн ХАСУМ-ийг хянан шалгах аас 19287 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, ажиллагаанд 327 мэдүүлэг хянагдаж байна. Хянасан урьдчилсан мэдүүлгийн тоо 2775 нэгжээр буюу 16.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4. Хянан шалгасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

Он	Хүлээн авсан	Өмнөх оны үлдэгдэл	Хянавал зохих	Хянасан	Үүнээс:				Ажиллагаанд
					АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг анхааруулсан	Илт ашиг сонирхлын зөрчилтэй	Хуульд заасан үндэслэлээр буцаасан	
2025	19203	411	19614	19287	17366	1426	85	407	327
2024	16767	156	16923	16512	14604	1265	48	595	411

Нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 85 этгээд тухайн албан тушаалд томилогдоход илт ашиг сонирхлын зөрчилтэй нь тогтоогдсон тул томилох эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хуульд зааснаар хянуулаагүй томилсон томилох эрх бүхий 37 албан тушаалтанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын хариуцлага тооцууллаа.

5.3. Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар Мэдүүлгийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зохион байгуулж, үр дүнг тооцох хүрээнд Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдээс 2019 оноос 2025 онд мэдүүлсэн мэдүүлгийн, үүнээс 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд мэдүүлсэн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийн илт ашиг сонирхлын зөрчилтэй нь тогтоогдсон нэр дэвшигчийн, шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон этгээдийн судалгаанд дүн шинжилгээ хийж, дүнг үйл ажиллагаанд ашиглаж байна.

5.4. Сургалт сурталчилгаа, мэдээлэл арга зүйн ажлын талаар Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, гарч байгаа нийтлэг зөрчил, зөрчлийг давтан гаргахгүй байхаас урьдчилан сэргийлэх, мэдүүлгийг бүртгэж хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ыг мэргэшүүлэх, сурган дадлагажуулах, үйл ажиллагаанд нь тавих хяналтыг чанаржуулах чиглэлээр сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг тасралтгүй зохион байгуулж байна.

Тайлант хугацаанд 37 удаагийн удаагийн сургалт (цахим, танхимаар)-д нийт давхардсан тоогоор 9747 хүнийг, үүнээс 4522 ЭБАТ, 5225 мэдүүлэг гаргагчийг хамруулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, сургалтад хамруулсан албан тушаалтны тоо 44,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 3. Сургалтад хамруулсан албан тушаалтны тоон үзүүлэлт (өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал)




Мэдүүлэг гаргагч албан тушаалтан нь хуулийн хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргийн талаар телевиз, сонин болон цахим хуудас, болон олон нийтийн мэдээллийн бусад хэрэгсэл, нийтийн сүлжээгээр дамжуулан сурталчилгааг тогтмол хийж мэдээ, мэдээллээр хангаж ажиллав.

Нийтийн албан тушаалтнаас хөрөнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө өгөх хүрээнд 5 төрлийн видеог бэлтгэж ЭБАТ-уудад хүргүүлж, байгууллагын цахим хуудас (www.iaas.mn)-д байршуулж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар мэдүүлэх хөрөнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар талаарх, мөн ЭБАТ-ын үйл ажиллагаанд зориулсан гарын авлагыг шинэчилж, холбогдох байгууллага, албан тушаалтан үйл ажиллагаандаа ашиглах боломжийг бүрдүүллээ.

5.5. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийн хяналт, шалгалтын ажлын талаар 2025 онд шинээр хүлээн авсан 101, өмнөх оны үлдэгдэл 24, нийт 125 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгах аас 110-г хянан шийдвэрлэсэн. Шийдвэрлэлт 88,0 хувьтай байна. Одоо 15 мэдүүлгийг хянан шалгах ажил үргэлжилж байна.

Хянан шийдвэрлэсэн 110 мэдүүлгийн 27 буюу 24,5 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 57 буюу 51,8 хувийг иргэдээс гомдол, мэдээллийн мөрөөр, 26 буюу 23,6 хувийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснээр хянан шалгасан байна.

Дүрслэл 4. Мэдүүлгийн хяналт шалгалтын тоон үзүүлэлт (өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал)



Хяналт шалгалтаар нийт 29 албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр томилох эрх бүхий албан тушаалтанд шаардлага хүргүүлснээс Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1-т зааснаар 2 мэдүүлэг гаргагчид сануулах, 13.8.2-т зааснаар 11 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, 13.8.3-т зааснаар 10 мэдүүлэг гаргагчид албан тушаал бууруулах, 4 мэдүүлэг гаргагчид 13.8.4-т зааснаар ажлаас халах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг зөрчсөн үйлдэлд мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т заасан албан тушаал бууруулах, 1 мэдүүлэг гаргагчид Авлигын эсрэг хуулийн 33.1.2-т заасан албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын хариуцлага ногдуулсан байна.

Хүснэгт 3. ХАСХОМ-ийн хяналт шалгалт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)


Хамаарах хугацаа	ХАСХОМ					Хариуцлага тооцсон
	Өмнөх оны үлдэгдэл	Хүлээж авсан	Шалгавал зохих	Хянан шийдвэрлэсэн	Ажиллагааны үлдэгдэл	
2025	24	101	125	110 (88.0)	15 (12.0%)	29
2024	101	204	305	281 (92.2%)	24 (7.8%)	49

Хяналт шалгалтаар 25 мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгт холбогдох Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдэл, мэдээллийг шалгуулахаар тус газрын харьяалах хэлтэст шилжүүлснээс 9 албан тушаалтанд холбогдох үйлдэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 3 албан тушаалтныг яллагдагчаар татаж, хэргийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар Нийслэлийн прокурорын газарт хүргүүлсэн байна.

Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй 7 мэдүүлэг гаргагчид холбогдох мэдээллийг Татварын ерөнхий газарт шилжүүлж, хамтарсан хяналт шалгалтаар 4,7 тэрбум төгрөгийн татварын зөрчилд 590,9 сая төгрөгийн төлбөр ногдуулсан байна.

5.6. Гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажлын талаар 2025 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 942 (өмнөх оны үлдэгдэл 64), нийт 1006 гомдол, мэдээллийг хянан шалгах аас тайлант хугацаанд 945 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд одоо 61 гомдол, мэдээлэл ажиллагаанд байна. Шийдвэрлэлт 94.0 хувьтай байна.

*Дүрслэл 5. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)*



Тайлант хугацаанд 945 гомдол, мэдээлэлд холбогдох 962 үйлдлийг хянан шийдвэрлэснээс 159 албан тушаалтанд холбогдох зөрчил тогтоогдож, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн эрх бүхий хэлтэст шилжүүлсэн 75, бусад хэлтэст шилжүүлсэн 4, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 129, хуульд зааснаар хянан үзээгүй болон буцаасан 119, зөрчил илрээгүй 474, бусад 2 байна.

Эрх бүхий хэлтэст шилжүүлсэн гэмт хэргийн талаарх 75 гомдол, мэдээллээс 2 гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж, 9 этгээдийг яллагдагчаар татсан, 28 үйлдэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа дүнтэй байна.

Гомдол, мэдээлэлд дурдсан нөхцөл байдлыг хянан шалгаж, ашиг сонирхлын зөрчил үүсэх эсхүл олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх нөхцөлийг үүсгэж байгаа талаар мэдэгдэж, анхааруулан, хууль зөрчсөн албан хаагчдад хариуцлага ногдуулах болон хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар шаардлага хүргүүлж ажиллав.

Зөрчил гаргасан 84 албан тушаалтанд сахилгын хариуцлага оногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд шаардлага хүргүүлснээс Авлигын эсрэг хуулийн 13.8.1-д зааснаар сануулах шийтгэлийг 7, 13.8.4-т заасан ажлаас халах шийтгэлийг 1, 13.9-д заасан албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр хасах сахилгын шийтгэлийг 3, 33.1.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр хасах шийтгэл бууруулах сахилгын шийтгэлийг 18, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр хасах шийтгэлийг 41, мөн хуулийн 29.2.3-т зааснаар албан тушаал бууруулах сахилгын шийтгэлийг 9, мөн хуулийн 29.2.4-т зааснаар нийтийн албанаас халах шийтгэлийг 5 албан тушаалтанд ногдуулсан байна.

Нийт гомдол, мэдээллийн 94,4 хувийг хуулийн анхны хугацаанд, 5.6 хувийг хуулийн хүрээнд хугацаа сунган шийдвэрлэсэн бөгөөд тайлант үед хугацаа хэтэрсэн тохиолдол бүртгэгдээгүй байна. Хугацаа сунган шийдвэрлэснийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Хүлээж авсан нийт гомдол, мэдээллийн 44.1 хувийг Улаанбаатар хотоос, 55.9 хувийг орон нутгаас ирүүлсэн байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, давтан гаргахгүй байх, үйл ажиллагаандаа хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар Монгол банк, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Батлан хамгаалах яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Завхан, Баян-Өлгий, Ховд аймгийн Засаг дарга, Барилгын хөгжлийн төв, “Цахилгаан амжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, Автотээврийн үндэсний төв зэрэг давхардсан тоогоор 33 байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, шаардлага хүргүүлж, үр дүнг тооцон ажиллалаа.


2025 онд шалган шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн агуулгын хувьд албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн 18.4 хувийг, бусдад давуу байдал олгосон 24.8 хувийг, ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус шийдвэр гаргасан 24.4 хувийг, хууль бус томилгоо хийсэн 23.2 хувийг, бусад 9.2 хувийг тус тус эзэлж байна. Энэхүү үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн зөрчил 24.8 хувиар буурч, бусдад давуу байдал олгосон зөрчил 11.3 хувиар, ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус шийдвэр гаргасан зөрчил 35.3 хувиар өссөн, хууль бус томилгоо хийсэн зөрчил 15.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гомдол, мэдээллийн хяналт шалгалтын хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлийн улмаас учруулсан 735,135,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх, мөн шийдвэр гаргахдаа бусдад давуу байдал олгосон, ашиг сонирхлын зөрчилтэй, мөн ашиг сонирхлын зөрчилтэй гэх ойлгогдохуйц нөхцөл байдлыг бий болгосон шийдвэрүүдийг хүчингүй болгох ажлыг хийлээ. Тухайлбал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн А/105 дугаартай тушаалын “Хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг томилсон 1 дүгээр хавсралтыг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ерөнхий шинжээч, шинжээч нарын “С.Э.Т” ХХК-д холбогдуулан гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтийг эрх бүхий албан тушаалтан нь хянан хүчингүй болгоод байна.

Зургаа. Мөрдөн шалгах ажлын талаар:


6.1. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл Мөрдөн шалгах хэлтсээс 2025 онд өмнөх оны 81, энэ оны 1766, нийт 1847 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 463 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлсэн. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. /2024 онд 1903/

*Дүрслэл 6. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)*




Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалын ангиллаар нь авч үзвэл, төрийн улс төрийн 194, төрийн захиргааны 482, төрийн тусгай 364, төрийн үйлчилгээний 79, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 164, бусад 46 байна.

Дүрслэл 7. Гомдол мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангилал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан өмнөх оны дугаартай 10, энэ оны дугаартай 1312, нийт 1322 гомдол, мэдээллээс 639 гомдол, мэдээлэл буюу 48.3 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 594 гомдол, мэдээлэл буюу 44,9 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 50 гомдол, мэдээлэл буюу 3,8 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 39 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 97.1 хувьтай байна.

Дүрслэл 8. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)




Мөрдөн шалгах хэлтэст хүлээн авч шалгасан 1322 гомдол, мэдээллийн 688 буюу 52,0 хувийг Улаанбаатар, 634 буюу 48,0 хувийг орон нутгийн прокурорын хяналтын харьяалалтай гомдол, мэдээлэл эзэлж байна.

6.2. Эрүүгийн хэргийн талаар Хуульд заасан харьяаллын 2259 үйлдэлтэй, 1369 холбогдогчтой, 1911 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг 2024 онд 1863 хэрэг шалгасантай харьцуулбал 2.5 хувиар өссөн байна.

Нийт шалгасан хэргийн 367 буюу 19,2 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 543 буюу 28,4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 53 буюу 2,7 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 4.6 хувь буюу 88 хэргийг нэгтгэн шалгаж, 1.8 хувь буюу 35 хэргийг түдгэлзүүлж, одоо 825 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 783 хэрэг, мөрдөн байцаалтын 42 хэрэг байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 57.0 хувьтай байгааг 2024 онтой харьцуулбал, шийдвэрлэлт 2,9 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт 367 хэргийг шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулбал 1,6 хувиар буурсан боловч шүүхээр 225 хэрэг (2024 онд 216) шийдвэрлэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 4.2 хувиар өссөн байна.

Дүрслэл 9. Хэргийн шийдвэрлэлт
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)




Ажиллагаанд 825 хэрэгт байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр ангилбал:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах) гэмт хэрэг-1419 буюу 62,8 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл (Хахууль авах) гэмт хэрэг-237 буюу 10,5 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл (Хахууль өгөх) гэмт хэрэг-172 буюу 7,6 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл (Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах) гэмт хэрэг-21 буюу 0,9 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл (Үндэслэлгүйгээр хөрөнгөжих) гэмт хэрэг-61 буюу 2,7 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл (Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах) гэмт хэрэг-43 буюу 1,9 хувь;
- Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах) гэмт хэрэг-60 буюу 2,7 хувь;
- Бусад хэрэг 213 буюу 9,4 хувийг тус тус эзэлж байна.


Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 116 буюу 8,5 хувийг төрийн улс төрийн, 244 буюу 17,8 хувийг төрийн захиргааны, 212 буюу 15,5 хувийг төрийн тусгай, 193 буюу 14,1 хувийг төрийн үйлчилгээний, 129 буюу 9,4 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 475 буюу 34,7 хувийг бусад этгээд эзэлж байна.

Дүрслэл 11. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан
(мөнх оны мөн үетэй харьцуулбал)



2025 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 674,748,879,840 (зургаан зуун далан дөрвөн тэрбум, долоон зуун дөчин найман сая, найм зуун далан есөн мянга, найман зуун дөч) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 163,115,202,225 (нэг зуун жаран гурван тэрбум, нэг зуун арван таван сая, хоёр зуун хоёр мянга, хоёр зуун хорин тав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 84,674,598,500 (наян дөрвөн тэрбум, зургаан зуун далан дөрвөн сая, таван зуун ерэн найман мянга, таван зуу) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

*Дүрслэл 12. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)*



6.3. Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн талаар 2025 онд 225 хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж, шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг өмнөх оны мөн үеэс 4,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

6.4. Бусад ажлын талаар Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих прокурорын 2023 оны 5 дугаар сарын 29-ний 4/02 тоот тогтоолын дагуу АТГ, ЦЕГ-ын даргын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/34, А/134 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын зээлийн сангаас төрийн өндөр албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүд хууль бус тэтгэлэг авч, эргэн төлөөгүй, мөн тэтгэлгийн мөнгийг хувийн дансаар авч завшсан, мөнгө угаасан байж болзошгүй гэх хэргийн мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна.

Улсын Ерөнхий Прокурорын газрын прокурорын 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 4/04 дугаартай тогтоолыг үндэслэн Нүүрс олборлолт, экспорт, боомтын нүүрсний тээвэрлэлт, төлбөртэй холбогдсон хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн А/101, А/119, А/326 дугаартай тушаалын дагуу томилогдсон 21 мөрдөгчийн бүрэлдэхүүнтэй хамтарсан ажлын хэсгээс нийт 103 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, 59 хэргийг шийдвэрлэснээс 83 холбогдогчтой 15 хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж, одоо 36 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

2025 онд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын гэрээний хүрээнд Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, АНУ, БНХАУ, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн эрх бүхий байгууллагад, Их Британийн Виржинийн арлуудын Ерөнхий прокурорын танхимд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хүргүүлж, Австри Улсад 2024 онд хүргүүлсэн гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг царцаах талаар талаар эрх зүйн туслалцааны хүсэлтийн хүрээнд 2025 онд мэдээлэл солилцон мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна. Япон Улсын Хууль зүйн яамнаас ирүүлсэн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг хүлээн авч, мөрдөн шалгах тодорхой ажиллагааг хийж гүйцэтгэн хариуг хүргүүлээ.

Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас бий болсон криптовалютыг олж илрүүлэн, Binance дахь дансыг эрх бүхий байгууллагаар дамжуулан гүйлгээний шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох арга хэмжээ авч, хэргийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар прокурорт хүргүүлсэн, цаашид уг криптовалютыг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахаар ажиллаж байна.

Тайлант хугацаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар холбогдох хуулийн этгээдэд 200 мэдэгдэл хүргүүлснээс 157 мэдэгдлийн хариуг хүлээн аваад байна.

ДҮГНЭЛТ

2025 онд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх газрын үндэсний хөтөлбөр, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг ханган биелүүллээ.

- Монгол Улс Ази-Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний 10 дахь удаагийн Жилийн бүгд хурлын даргалагч улсаар сонгогдсоны хувьд тус бүгд хурлыг 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдрөөс 9 дүгээр сарын 26-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Хуралд хөрөнгө буцаах сүлжээний гишүүн орнууд, хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын болон бүс нутгийн, үндэсний хэмжээний авлигатай тэмцэх байгууллага, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Ойрх Дорнод, Хойд Африкийн хөрөнгө буцаах байгууллагуудын сүлжээний буюу 3 олон улсын байгууллага, 13 гадаад улс орны 60, Монгол Улсын хууль сахиулах чиг үүрэг бүхий 13 байгууллагын 90, нийт 150 зочид, төлөөлөгчид оролцов. Бүс нутгийн хэмжээнд авлигатай тэмцэж, шударга ёсыг бэхжүүлэх, хууль бус хөрөнгийн урсгалыг таслан зогсоох улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго бүхий энэ удаагийн хурлаар “Цахим хөрөнгийг буцаан авах ажиллагаа болон хөрөнгийн менежментийн эрх зүйн зохицуулалт” үндсэн сэдвийн хүрээнд цахим хөрөнгийг буцаан авахад хиймэл оюун ухааны AI технологи хэрэглэх арга зам, сайн туршлага, яллахгүйгээр хөрөнгө хураан авах эрх зүйн зохицуулалт, бүс нутгийн хамтын ажиллагаа, хураагдсан хөрөнгийн менежментийн шинэ тренд зэрэг асуудлаар Австрали, Тайланд, Малайз, Филиппин, Папуа Шинэ Гвиней, Энэтхэг, Шинэ Зеланд улсын төлөөлөгчид илтгэл мэдээлэл хэлэлцүүлэн, олон улсын сайн туршлагаа хуваалцлаа.
- Малайз Улсын Авлигатай тэмцэх хорооны дарга Тан Шри Дато' Шри Азам бин Баки тэргүүтэй төлөөлөгчид, Тайландын Хаант Улсын Авлигатай тэмцэх үндэсний хорооны төлөөлөгчид ажлын айлчлал хийж, байгууллага хоорондын найрсаг харилцаагаа улам гүнзгийрүүлэн хөгжүүлж, албан хаагчдыг мэргэшүүлэн сургах, харилцан туршлагаа солилцохоор харилцан тохирч, “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээний бүгд хуралд танилцуулагдсан Истанбулын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторингийн тайланг хүлээн авсан бөгөөд холбогдох байгууллагуудад зөвлөмжийг хүргүүллээ.
- Дэлхийн банк, Монгол Улсын Засгийн газар хоорондын “Ухаалаг засаг 2” төслийн хүрээнд мэдүүлгийн бүрдүүлэлт /mediuuleg.iaac.mn/-ийн болон хяналт шалгалт/iad.iaac.mn/-ын системүүдийг бүрэн шинэчилж 2025 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүллээ.

- Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хяналт шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэгдлээ.
- Байгууллагын хэмжээнд 2025 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн 3034 гомдол, мэдээлэл хүлээн авснаас Мөрдөн шалгах хэлтэст 1766 буюу 58,2 хувь, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст 949 буюу 31,3 хувь, Гүйцэтгэх ажлын хэлтэст 164 буюу 5,4 хувь, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст 95 буюу 3,1 хувь, Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албанд 58 буюу 1,9 хувь нь тус тус хуваарилагдан хянан шалгагдсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, өргөдөл, гомдол, мэдээлэл 88 нэгжээр буюу 3,0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт хэрэгжилт 66,1 хувь, Төрийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт дунджаар 66.6 хувьтай үнэлэгдэв.
- Авлигын эсрэг хуулиар хүлээсэн үүргийн дагуу 17 салбарт хамаарах 244 шийдвэр, дүрэм, журмыг хянаж, саналыг хүргүүлснээс эрх бүхий байгууллагаас 101 захиргааны хэм хэмжээний актыг бүхэлд нь хүчингүй болгож, 6 актын холбогдох хэсгийг хүчингүй болгон шийдвэрлэсэн байна.
- Авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор нийт 610 удаагийн сургалтад 41999 хүнийг хамруулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, зохион байгуулсан сургалтын тоо 13.3 хувиар, сургалтад хамрагдсан хүний тоо 13.9 хувиар өссөн байна.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн 50 байгууллагын 117 албан хаагчийг сургагч багшаар бэлтгэх сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олголоо.
- Авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр давхардсан тоогоор 79 байгууллагад 85 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- “Шударга байдлын үнэлгээ-2025”, “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”, Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаа”-г хийж, “Уул уурхайн салбар дахь авлигын эрсдэлийг үнэлэх аргачлал”, “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг боловсруулав.
- Нийтийн албан тушаалтны 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 130 байгууллагын 48841 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ мэдүүлж, баталгаажууллаа.
- ХАСХОМ-ийн хяналт шалгалтыг Татварын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж, 4,7 тэрбум төгрөгийн татварын зөрчилд 590,9 сая төгрөгийн төлбөр ногдуулсан байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдлын шалгалтаар 735,1 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх нөхцөлийг бүрдүүллээ.
- 2025 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 674,748,879,840 (зургаан зуун далан дөрвөн тэрбум, долоон зуун дөчин найман сая, найм зуун далан есөн мянга,

найман зуун дөч) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 163,115,202,225 (нэг зуун жаран гурван тэрбум, нэг зуун арван таван сая, хоёр зуун хоёр мянга, хоёр зуун хорин тав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 84,674,598,500 (наян дөрвөн тэрбум, зургаан зуун далан дөрвөн сая, таван зуун ерэн найман мянга, таван зуу) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

- Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 2024 онтой харьцуулбал 2,9 нэгжээр өсч, 2025 онд 225 авлигын гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цаашид Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж, гүйцэтгэлийн чанарт ахиц гаргах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын арга барилыг өөрчлөн шинэчлэх, авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хулгайлагдсан хөрөнгийг буцаан авчрах, үндэслэлгүй хөрөнгөжих зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, хариуцлага тооцох, албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр онцгой анхаарч ажиллах нь зүйтэй.

--oOo--